



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 46

Арвайхээр

"Нэг өрх-Нэг ажлын байр" сумын хөтөлбөрийн
2017 оны хэрэгжилтийг үнэлэх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Нэг өрх-Нэг ажлын байр" сумын хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт, үр дүнг 96.57 хувь буюу "Хангалттай" гэж үнэлсүгэй.

2. Хөтөлбөрийн хүрээнд сар бүрийг зорилтот үйл ажиллагааг төлөвлөн үр дүнд хүрэх чиглэлийг хэвшүүлж ажиллахыг байгууллагын удирдлагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын нийт албан хаагчдад, хэрэгжилтийн явц, үр дүнг байгууллага, албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тусган биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.АМАРТҮВШИН